



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 08 өдөр

Дугаар *А/чм*

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Усны эх үүсвэрийг хамгаалах, хуримтлуулах, зүй зохистой ашиглах зорилгоор усан хангамжийн төвлөрсөн шугам сүлжээний 2-р шатны ажил (Могод сум) гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "БТРБ" ХХК-тай 469,930,961 (дөрвөн зуун жаран есөн сая есөн зуун гучин мянга есөн зуун жаран нэг) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т, тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "БТРБ" ХХК-ийн захирал (А.Тэгшзаяа)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сасаг Ажил 2026 өдөр бүр 6326010651

6326010651

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 08-ны/ний өдрийн
А/дм дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадалшгүй ажил	8,159,941	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	8,159,941	Ү.Бямбасүрэн
3	Нормчлолын сан	734,395	Ү.Бямбасүрэн
4	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Очирсүрэн
5	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Очирсүрэн Ү.Бямбасүрэн
6	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Очирсүрэн
7	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 90 хоног	Ү.Бямбасүрэн

--o0o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 08-ны/ний өдрийн
... дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	УХАТ инженер	Х.Чимгээ	Ү.Бямбасүрэн
2	ХАБЭА-н ажилтан	Э.Отгон-Эрдэнэ	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Экскаватор	0642 ММВ	
2	Автокран	3290 УВЕ	
3	Ачааны автомашин	8647 УЕУ	

--о00о--